



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/285

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, мод тарих, мод үржүүлэгийн газар байгуулахад зориулан газар ухах, хагалах зориулалт бүхий механизм (трактор) худалдан авахад зориулан 56,000,000 төгрөгийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 56,000,000 төгрөг (тавин зургаан сая)-ийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.1-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг дарга 2021 оны
05 дугаар сарын 09-ний өдөр
А/285 дугаар захирамжийн
хавсралт

**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ЗОРИУЛАН ГАЗАР УХАХ,
ХАГАЛАХ ЗОРИУЛАЛТ БҮХИЙ МЕХАНИЗМ (ТРАКТОР) ХУДАЛДАН АВАХ
ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Нийт дүн (төгрөг)	Тайлбар
1.	Ухах, хагалах зориулалт бүхий механизм	ширхэг	1	56,000,000	56,000,000	Тарих модны нүх ухах, суваг шуудуу гаргах зориулалт бүхий механизм
Дүн					56,000,000	-

-оОо-